ИХ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЦААЗНЫ УЛАМЖЛАЛ (ИЛ ХАНТ УЛСЫН ЖИШЭЭН ДЭЭР)

THE JURISPRUDENCE TRADITION IN THE GREAT MONGOLIA (IL KHANT STATE AS EXAMPLE)

Ц.Минжин. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн Дундад зууны Монголын түүхийн салбарын эрдэм шинжилгээний ажилтан, доктор
Minjin.Ts. Institute of History Mongolian Academy of Sciences, Department of Mongolian Medieval History Researcher, Ph.D

Abtsract: "Ikh zasag" is one of the big jurisprudence sources that reflects society, economy and politics of the Great Mongolia and also give possibility to study the society in different way. Understanding of the historiography on the Ikh zasag and Il khant state jurisprudence by Moslem Historians will be clarified. There were norms that derived from the "Ikh zasag" in the Il khant state jurisprudence as show several examples despite the jurisprudence that show the Moslem world specific feature as show the sources and research articles and works.

Их Монгол Улсын эрх зүйн түүхэн уламжлалынхаа хувьд Монголын нутаг дэвсгэрт оршин тогтнож байсан эртний улсууд болон овог, аймаг, ханлигуудын эрхийн цааз нь дан ганц хэв хууль ёс заншил байсангүй харин хааны болон ханы мөн овог аймгийн ахлагчдын эрх ашгийг хамгаалж, тэдний хүсэл зоригийн илэрхийлэл болгож тогтоосон хэм хэмжээ зэрэгцэн үйлчилж байжээ.

Өөрөөр хэлбэл, өмнөх овог, аймаг, ханлиг, улсуудынхаа мөрдөж байсан эрхийн болон зан заншлын хэм хэмжээг дараа дараачийн улс нь ямар нэгэн байдлаар уламжлан авч өөр өөрсдийн онцлогийг гаргасан эрхийн цаазыг төрийн (хааны) бодлогоороо дэмжих мөн шинээр бүрэлдэн бий болж байгаа нийгмийн харилцааны зарим чухал хэсгийг нэмэн зохицуулах замаар баяжуулж иржээ.

Чингис хаан олон овог аймгуудыг төрийн нэг жолоонд оруулан, Монгол Улсыг байгуулахын төлөөнөө эрмэлзэн тэмцэж байсан нь 1206 онд нэгдсэн тулгар төр улс байгуулагдсанаар сая бодит биеллээ олсон билээ. Шинээр байгуулагдсан олон овог, аймгийн хүн ардад эв найртай түвшин төрийг бий болгоход өнө эртнээс уламжилж ирсэн монгол зан заншил, ёс суртахуун, хэв хуулийг амьдрал ахуйдаа мөрдлөг болгож байсан хэдий ч тэр нь тухайн үеийнхээ "Их Монгол улс"-ын хууль цаазны шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байв.

Ийм болохоор Чингис хаан олон овгийн хүмүүсийг нэгтгэн захирах явдалд төрийн хууль цааз зайлшгүй шаардлагатай байгааг ухамсарлаж, ийм хууль нэн даруй гаргах асуудлыг дэвшүүлэн тавьсан нь тухайн үеийн цэрэг, иргэний төрийн шинж чанар хийгээд нүүдэлчин ахуйн өвөрмөц онцлогийг тусгасан "Их засаг" юм.

Их Монгол Улсын "Их засаг" нь урьдын мөрдөгдөж байсан уламжлалт зан заншлын хэм хэмжээ болон өмнөх хаадын тогтоосон хэм хэмжээ түүнчлэн Чингис хааны ба залгамжлагч хаадын өөрийн хүслийн дагуу шууд зарлигдан тогтоосон хэм хэмжээ, их хуралдай буюу сэцдийн зөвлөлөөр хэлэлцэн тогтсон хэм хэмжээ, эцэст нь Шихихутагийн болон хойшдын заргачдын тогтоосон хэм хэмжээнээс "Их засаг" бүрдэлдэн бий болж байжээ.

Дээр өгүүлснээр "Их засаг"-ын үндсэн бүрдэл нь 1206 он гэхэд бий болсон бөгөөд үүнээс хойш нэмэлт оруулах замаар тухайн үеийн нөхцөл байдалд зохицуулан баяжуулж иржээ. Сурвалж бүтээлүүдэд тэмдэглэгдсэнээр хамгийн гол нэмэлтүүдийг их хуралдай хуралдахад хэлэлцдэг байсан нь ажиглагдана.

Их Монгол Улсыг хэмжээгүй эрхт хаант засаглалтай хэмээн тодорхойлох боловч олон асуудлыг харилцан

уялдаа бүхий Их хуралдай, Сэцдийн зөвлөл болон Шихихутагийн удирдсан Шүүх байгууллагаар дамжин хэрэгжүүлж байжээ.

Ийм ч учраас Монгол төрийн бодлого хэрэгжихдээ хууль цаазын хүчийг онцгой сайн ашиглаж, Их засаг хуулийг нийгмийн бүх давхаргын хүмүүс төдийгүй дагаар орсон, байлдан дагуулсан газар нутгуудад ч хууль зүйн дээд хүчин чадалтай үйлчлэх нөхцлийг бүрдүүлж өгчээ.

Их Монгол улсын нийгэм, эдийн засаг, улс төрийн тусгал болж тухайн нийгмийг олон талаас тольдох нэгэн томоохон эрх зүйн эх сурвалж нь "Их засаг" юм.

"Их засаг" нь зарлиг, зарга, ёсын нэгдмэл цогц бөгөөд эрх зүйн болон гүн ухааны хувьд сайтар бодож боловсруулсан хүчтэй тогтолцоог бий болгожээ. Өөрөөр хэлбэл хэм хэмжээ тогтоосон зарлиг нь төрөөс буюу хаанаас тогтоосон хууль буюу хуульчилсан акт, зарга нь гэмт хэрэг буюу хэрэг шийдэх үндсэн зарчим, шүүхийн жишиг, ёс нь зан заншилын хэм хэмжээг өөртөө шингээсэн хэв хуулийн шинжтэй хэм хэмжээ буюу ёс суртахуунд нөлөөлхүйц заншилын хэм хэмжээ болно.

"Их засаг" үүсэн бүрэлдсэн нь "Их монгол" улс байгуулагдсаны бодит үр дүн бөгөөд Эзэнт гүрний нутаг дэвсгэрт хууль эрхийн дээд хүчин чадалтай хэрэгжиж, цаг хугацааны бүхий л үеийн хууль цаазад зохих ул мөрөө үлдээжээ.

Чингис хааны байгуулсан Их Монгол улс, Монголын Эзэнт Гүрний бүрэлдэхүүн улсуудын төрийн бодлого нь тухайн үедээ дэлхий хэмээн ойлгогдож байсан Евроазийн тэрхүү орон зайд өөрийн ноёрхлоо тогтоон, тэдгээр орнуудын улс төрийн агуулга, зохион байгуулалт, эрх зүйн хэлбэр, нийгмийн амьдралд хүчтэй нөлөө үзүүлж байжээ.

ИХ ЗАСАГ БА ИЛ ХААНТ УЛСЫН ХУУЛЬ

Мөнх хааны зарлигаар Исламын ертөнц дахь Аббасидын Калифыг устгахаар Иранд анх илгээгдсэн Эзэн Чингис Хааны ач хүү Хүлэгү Иран, Кавказын чанад, Дундад Ази, Афганистан, Месопотами, Бага Азийн зүүн хэсгийг өөртөө багтаасан Ил хаант улсыг үүсгэн байгуулав

Ил хаант улсаас эзэнт гүрний бүрэлдэхүүн улсуудтай харилцахад гадаад дотоодын олон хүчин зүйлс нөлөөлж байснаас гадна исламын шашинт харьяат иргэдээ захирахад "Их засаг" хуулиас гадна тухайн бүс нутагт хэрэгжиж байсан хууль эрхэмжүүд, зан заншилын хэм хэмжээнүүд ихээхэн үүрэг гүйцэтгэж байв.

Ил хаант улсын хууль цаазыг тайлбарлахын өмнө Их Монгол улсын "Их засаг"-ийг исламын ертөнцийнхөн хэрхэн ойлгож байсныг тайлбарлах хэрэгтэй. Чухам энэ л нутгийн мэргэдийн бичсэн сурвалжуудад хууль эрхийн хэм хэмжээний тухай дурдсан нь олон.

Тухайлбал, Дэлхийг байлдан дагуулагчийн түүх, Абул фаражийн түүх, Судрын чуулган, Нум сумтан ард түмний түүх, Ил улсаар туурвин үзсэн тэмдэглэл, Египтийн ойллого, Ибн Баттутагийн замын тэмдэглэл зэрэг сурвалжууд нь бүгд исламын шашинт хүмүүсийн гараар бичигджээ. Үүнийг онцлохын учир нь Монголын уламжлал, зан заншил, бөө мөргөлийн зан үйл болон исламын шашны зан үйл, тэдний өдөр тутмын амьдралын хэвшил нь хоорондоо ихэд зөрүүтэй байхаас гадна зохиогчдын өөрсийн байр суурь бүтээлд нь ихээхэн нөлөөлсөн гэдгийг ч зарим эрдэмтэд[271] бичсээр байна.

Ил хаант улсын түүхэн үед амьдарч байсан Макризи[272] нь олон эрдэмтдийн Монголын анхны бичмэл хууль цаазын судалгааг хийхэд гол анхаарлаа хандуулж ирсэн "Их засаг"-ийн зурвасуудын тухай мэдээлсэн болно.

XIX-XX зууны "Их засаг" судлаачдын гол эх сурвалж нь болсон Макризийн бүтээл болох *Египтийн тэмдэглэл-д* "Их засаг"-ийн зурвасуудыг тусгайлан тэмдэглэснээр онцлог юм.

Макризийн тэмдэглэлийг ал-Умарийн *Ил улсаар туурвин үзсэн тэмдэглэл* болон Жүвейнийн *Дэлхийг байлдан дагуулагчийн түүх* дэх засгийн тухай тэмдэглэлтэй харьцуулж, Макризи бол ал-Умаригийн тэмдэглэлийг хуулбарласан бөгөөд ал-Умаригийн тэмдэглэл нь Жүвэйнигийн тэмдэглэлээс үүсэлтэй хэмээн, өөрөөр хэлбэл XIII зууны Жүвэйнигийн бичлэгийг XIV зуунд ал-Умари XV зуунд Макризи агуулгын хувьд дамжуулсан болохыг[273] P.Ratchnevsky 1969 онд, D.Ayalon 1971 онд, D.Aigle 2004 онд бичжээ.

Макризи нь Монголчуудын Яасаг баримталж буй эрх мэдэлтнүүд нь исламын ертөнцийн аугаа их хууль гэгдэх Шариатад[274] хичнээн их аюул учирч

[271] D'Ohsson, Silvestre de Sacy, Hammer-Purgstall, Berezin, Popov, Bartold, Vladimirtsov, Riayanovsky, Vernadsky, Alinge, Poliak, D.Ayalon, Denise Aigle…

[272] Al-Maqrīzī бас Muhammad al-Maqriz, түүний бүтэн нэр нь Taqi al-Din Ahmad ibn ,Ali ibn ,Abd al-Qadir ibn Muhammad al-Maqrizi, арабаар تقى الدين أحمد بن على بن عبد القادر بن محمد المقريزى. Макризи бол исламын шашины Суннитийн урсгалыг баримтлагч араб хүн бөгөөд 1364 онд Египтийн Кайр хотод төрж 1442 онд 78 насандаа тэнгэрт хальжээ. Макризи нь Мамлюкийн үеийн арабын нэрт түүхч бөгөөд түүний 200 гаруй бүтээл тууривсны нэг нь "Египтийн тэмдэглэл" (kitāb al-Mawā' iz wa-l-i' tibār bi-Dhikr al-khitat wa-' l Āthār) гэдэг зохиол бөгөөд эдүгээ Персийн хаадын номын санд хадгалагдаж байна. Уг бүтээлд Монголын эзэнт гүрний "Их засаг"-ийн тухай тэмдэглэлийг үе үеийн эрдэмтэд ихэд сонирхон судалсан.

[273] Ratchnevsky P. Die Yasa (Jasaq) Čhinggis-Khans und ihre Problematik. Sprache, Geschichte und Kultur der Altaischen Vцlker, Berlin, 1974.s.481, Ayalon D. The Great Yāsa of Chingiz Khān. A Reexamination (Part A). -// Studia Islamica, No. 33. (1971), p.104, Denice Aigle. Le grand jasag de Gengis-khan, l'empire, la caulture mongole et la sharīa. -//Journal of the Economic and Social History of the Orient , vol.47, No1 2004.p.41

[274] Шариат нь аш-шириа буюу шулуун зөв зам мөр гэсэн үг бөгөөд ислам шашны хууль цааз, эрх зүйн номлолыг тусгажээ. Түүний тулгуур эх үндэс нь Коран болон Сунна

байгааг харуулснаараа тэрээр өөрийн нэр хүндийг өндөрт өргөжээ. Энэ ч утгаараа Шариат бол исламын шашинтай хүмүүсийн үзэл суртлын гол зэвсэг нь болж, исламын шашинт орнуудын хууль шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд чухал байр суурь эзлэх болсон байна. Иймээс исламын шашинт Макризи нь монголын төрийн эсрэг үзэл санаатай байгаад зогсоогүй Ал-Умаригийн бүтээлийг хуулбарласнаа ч нуун дарагдуулснаар хожмын үеийн "Их засаг" судлаачдыг ч ихээхэн төөрөгдүүлжээ. Макризийн бичвэр нь тухайн үедээ домогшиж байсан "Их засаг"-ийн тухай сөрөг ойлголт төрүүлэх гэсэн оролдлого нь харин ч түүнийг дэлгэрүүлэхэд хүчтэй нөлөө үзүүлжээ.

Энэ тухай судлаач Aigle "Аль-Умари зохиолдоо анх удаа "Чингис хааны тогтоосон дүрэм (qawāʿid) ба монголчуудын ёс заншил (ādāb)-ын жагсаалтыг гаргасан. Гэвч тэр Чингис хааныг хууль тогтоогч гээгүй төдийгүй, ясагийн олон зүйл шариатын хуультай зөрчилддөг гэх төдийгөөр өнгөрсөн байна. Аль-Макризи дээрх зохиогчийн хийсэн жагсаалтыг шууд ашигласан боловч өөр дүгнэлт хийсэн. Тэр ясагийн лалын шашны эсрэг шинжийг тодруулан харуулахын тулд "хууль" хэмээн нэрлэж, Чингис хааныг энэ хуулийг тогтоосон"[275] гэжээ.

Ингээд "Макризи исламын хууль зүйн нэр томъёонуудыг ясаг тайлбарлахдаа анх ашигласан байна.

- "Чингис хаан хууль (sharaʿa) тогтоосон"
- "тэр хориг (sharaṭa) буулгасан"
- "тэр зарлигдсан (alzama)"
- "тэр хориглосон (manʿa)"

гэдэгт гарч буй араб үгнүүд бүгд хууль зүйн нэр томъёонууд юм. Үнэндээ аль-Умарийн хориг гэж үзсэн зүйлсийг аль-Макризи Чингис хааны тогтоосон хууль болгон гуйвуулсан юм"[276] гэжээ.

Denise Aigle-ийн үзэж байгаагаар " Я с а г и й н тухай ойлголт Мамлюкийн түүхчдийн хувьд XIII зуунаас XV зуун хүртэлх хугацаанд нэлээд өөрчлөгдөн хувьсчээ. Ал-Умари Чингис хааны олон зарлиг лалын шүтлэгтэй зөрчилддөг тухай бичиж байсан бол хожуу үеийн Ал-Макризи ба Ибн-Арабшах нар илэрхий дайсагнасан байдлаар яса ба шариатын хуулийг сөргүүлэн тавьсан байдаг. Яг энэ үед хэдийгээр лалын шашинтан боловч Чингис хааны үеийн дэг журмыг сэргээн тогтоохыг хичээгч гэж үзэгдэж байсан Доголон Төмөр хаан Левитаны улс орнуудад аюул занал учруулж байсан нь энэ шинэ хандлагад нөлөөлсөн нь эргэлзээгүй"[277] гэжээ.

Эзэнт гүрний бүрэлдэхүүн улсуудад дээд хүчин чадалтай үйлчилж байсан "Их засаг" нь Чингис хаан 1206 онд хаан суугаад "Гүр иргэний хувь хувилсныг, зарга заргалсныг, хөх дэвтэрт бичиг бичиж дэвтэрлэх"[278] зарлиг буулгаснаас үүдэлтэй юм. Энэ ч утгаараа "Их засаг" нь Ил хаант улсад тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд бөө мөргөлтөн байсан монголчуудын зан заншилаар уламжлан тогтсон хэм хэмжээ, мөн хаадын зарлиг нь исламын шашинтуудын ахуй байдалд нийцэхгүй нь олон байсныг үгүйсгэх аргагүй юм. Эдүгээ ч зан заншлын буюу хорио цээрийн шинжтэйгээр уламжлагдан үлдсэн "мал муулах", "усны хэрэглээ" зэрэг нь исламын ертөнцийн өдөр тутмын амьдралын хэвшилтэй зөрчилдөж байсныг аль-Макризи ба Ибн-Арабшах нарын түүхчид тодруулан бичжээ.

Усыг хайрлан гамнах, бохирдуулахгүй байх зэрэг нь Монголчуудын ахуй амьдралтай ч салшгүй холбоотой бөгөөд исламын шашны өдөрт таван удаа угаалга хийж байж мөргөл үйлдэх гэсэн усны хэрэглээтэй холбоотой зан үйлтэй зөрчилдөж байгаа ч "Их засаг"-ийг дагах ёстой гэдгийг сурвалжийн мэдээ харуулж байна.

Макризийн бичвэр дотор байгаа устай холбоотой зурвасууд нь анх Жувейнигээс эхэлсэн бөгөөд Рашид ад дин, Ал-Умаригаар дамжин түүнд хүрчээ. Тиймээс Макризийг ор хоосон зүйлээс, өөрөө санаанаас зохиосон зүйл бичсэн гэж хэлж боломгүй, харин хаана, хэдий хугацаанд ямар байдалтайгаар зүсээ хувилган түүнд хүрсэн гэдгийг нь судлах хэрэгтэй. Түүний бусад зурвасуудын хувьд ч мөн адил бусад сурвалжтай агуулгын хувьд давхцаж байдаг зүйлс бий.

Монголчууд 1218 оноос исламын ертөнцөд анх нэвтэрсэн нь тэдэнд хүчтэй цохилт болсон төдийгүй цааш монголчуудын ноёрхол тогтоход "Их засаг" -ын үзэл санаа ихээхэн хүчтэй нөлөө үзүүлжээ. Энэхүү нөлөөг бий болгоход "Их засаг"-ийн зурвасуудыг

1. Тулгасан
2. Буулт хийсэн
3. Тухайн бүс нутагт барих бодлогоо тодорхойлоход ашигласан байна.

Ил хаант улсын үед "Их засаг" нь эрх зүйн дээд хүчин чадалтайгаар үйлчилж байснаас гадна тухайн бүс нутгийн хууль эрхийн зурвас буюу исламын шашны Шариатын хууль давхар үйлчилж байсныг үгүйсгэж болохгүй. Энэ тухай доктор И.Дашням "Хүлэгү, Абага, Гайхалт, Аргун, Газан гээд Ил хаадууд их засаг хуулийг хатуу чанд даган биелүүлэхээ зарлиглан тунхаглаж, хэлбэрэлтгүй сахин мөрдөж

юм. Мусулманчууд өнөө цагийн хууль эрх зүйн өнгө аясаар шариатын хуулиа өөрчлөхөд их анхаарах болжээ. Шариатын хууль гэдэг нь Коран судар болон Суннад тулгуурлан мусульман хүний мөрдөх ёстой хууль ёсыг бүхэлд нь хэлдэг.

275 Denice Aigle. Le grand jasag de Gengis-khan, l'empire, la caulture mongole et la sharīa. -//Journal of the Economic and Social History of the Orient , vol.47, No1 2004.p.41

276 Denice Aigle. Le grand jasag de Gengis-khan, l'empire, la caulture mongole et la sharīa. -//Journal of the Economic and Social History of the Orient , vol.47, No1 2004.p.42

277 Denice Aigle. Le grand jasag de Gengis-khan, l'empire, la caulture mongole et la sharīa. -//Journal of the Economic and Social History of the Orient , vol.47, No1 2004.p.68

278 Монголын нууц товчоо. Шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа. УБ., 2006. 203§

байв. Ийнхүү "Их засаг" хууль Ил хаант улсын эрх зүйн эх сурвалжийн анхны төрөл болон хэрэгжсэн болой" [279] гэж дүгнэжээ.

Иймд Ил хаант улсын эрх зүйн эх сурвалжид "Их засаг" тэргүүлэх байр суурьтай байсан гэж үзвэл Чингис хаан болон Их Монгол улсын Өгэдэй, Гүюг, Мөнх хаадын зарлиг, тухайн үед мөрдөгдөж байсан хэм хэмжээнүүдийг хамруулан ойлгож болно. Үүнд Чингис, Өгэдэй, Гүюг, Мөнх хаанаас баруун тийш явуулсан аян дайнтай холбогдуулан гаргасан зарлиг, тус нутагт ээмшил нутаг газар олгосон, даргач, элч томилсон зарлигуудыг Ил хаант улсын анхдагч эх сурвалж гэж үзвэл Ил хаадын өөрсдийн гаргасан зарлиг, тухайн бүс нутагтаа тогтоосон хууль, дүрэм, журмууд нь эрх зүйн эх сурвалжийн хоёр дахь хэлбэр болно.

Хожим нь Их Монгол улсын бүрэн эрхийг залгамжилсан Юань улсын хууль цааз хэдийгээр бүрэн эхээрээ мөрдөгдөөгүй ч төрийн бодлогын хувьд Ил хаант улсад тодорхой нөлөө үзүүлж байсан билээ. Тухайлбал: Ил хаант улсын хааныг батламжлах, төрийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шүүн хэлэлцэх, төр шашин хоорондын харилцаанд болон дипломат ёс журамд Юань улсаас тогтоосон хэм хэмжээг мөрдөж байсан гэж үзвэл эрх зүйн эх сурвалжийн гурав дахь хэлбэр болно.

Ил хаант улсын ард иргэд эртний улалмжлалт соёлтой бөгөөд тэдний зан заншлын хэм хэмжээ, шашины номлол тухайлбал коран судар болон шариатын хуулиа ихэд дээдлэн, дагаж баримтлах нь түгээмэл байсан. Энэ уламжлан тогтсон хэм хэмжээ нь Ил хаант улсын эрх зүйн эх сурвалжид зүй ёсоор тооцогдож байв.

Чингис хааны "Их засаг"-аас улбаатай хэм хэмжүүд Ил хаант улсын эрх зүйн тогтолцоонд онцгой байр суурь эзлэж байсан нэг жишээ нь өртөөний алба байв. "Их Монгол улсын морин өртөөг өөрийнхөө нутгаар дайран, газар нутагт морин өртөөний буудлуудыг 30 км тутамд байгуулж шөнө өдөргүй ажилдаг болгон тохинуулсан байна. Араб, Каспин, Хар, Газрын дундат тэнгис, Лоб, Ван, Уремын нуур, Тигр, Евфрат, Амударъяа, Сырдаръяа, Эрчис мөрөн, Или, Яркенд, Хотон гол усан замын сүлжээ болж, тэдгээрийн сав газар, эргээр худалдааны хот суурингуудын худалдааны бааз зах болгон хөгжүүлэх, зарим хот сууринг шинээр байгуулж, худалдаа хөгжих баазыг бүрдүүлсэн байна."[280] Эндээс харахад Монголчуудын хуурай газраар явдаг морин өртөөг өргөтгөн усан замын сүлжээг бий болгосон нь илүү дэвшилтэд харилцааг үүсгээд зогсоогүй Самарканд, Бухар, Алеппо, Багдад, Хорасан, Алмутын хотуудыг байлдааны үед сүйдсэнийг дахин сэргээн засварласнаас гадна Султанийе, Аргунийе, Газанийе гэх Ил хаадад зориулсан шинэ хот байгуулжээ. Тус хотуудад Ил хаант улсын төрийн бодлогоор худалдаа арилжаа, гар урлал, ахуйн өргөн хэрэглээний бараа, барилгын материал, цэргийн зэвсэгийн үйлдвэрлэл зэргийг хөхүүлэн дэмжиж, татварын хөнгөлөлт үзүүлэх, зээл олгох зэргээр хууль эрх зүйн таатай орчинг бүрдүүлж өгчээ. Ийнхүү Ил хаант улсын хууль цааз "Их засаг"-аас эхтэй хэмээн үзэж, исламын ертөнцөд түүнийг тулган хүлээлгэж, хэрэгжүүлж байсан гэвэл энэ тухай исламын түүхэн сурвалжуудаас илүү олон баттай мэдээг олж үзэж болох юм.

Их Монгол Улсаас бүрэлдэхүүн улсуудад уламжлагдан ирсэн төрийн дээд байгууллага болох Их хуралдайг Ил хаант улсад ч мөн адил уламжлан авчээ.

Сурвалж бичгүүд болон судалгааны зохиолуудад Чингис хаан амьд сэрүүн байхдаа лавтайяа гурван удаагаа сүр дуулиантай их хуралдайг хуралдуулсан тухай[281] тодорхой өгүүлсэн бол Ил хаант улсын Хүлэгүгийн угсааны хаадыг өргөмжлөхөд их хуралдай хуралдуулсан мэдээг[282] мөн тэмдэглэсэн байна.

Их Монгол Улсын хуралдайг академич Ж.Болдбаатар "Энэ үеийн их хуралдай нь эртний улсуудын үеийнхээс зохион байгуулалт, хэлбэрийн хувьд тун боловсронгуй болж, төрийн дээд байгууллагын шинжийг илүүтэй агуулах болжээ. Чухамхүү энэ утгаар нь зарим судлаачид Их хуралдайг парламент ёсны дээд өвөг хэмээн үздэг тал бий. Ямар ч байсан тухайн үедээ л тодорхой хэмжээгээр ардчилал хөгжиж байсны тов тодорхой нотолгоо нь Их хуралдайн үйл ажиллагаа лавтайяа мөн. Хамгийн гол нь хэн бугай ч Их хуралдайг алгасаж хааны титэм хүртэх хууль зүйн болон ёс суртахууны эрхгүй байсан явдал юм. Чухам үүгээр Их хуралдайн эрх сүр, хүчин чадал илэрхийлэгдэх аж"[283] хэмээсэн тодорхой дүгнэлттэй санал нэгдэхийн учир нь "Их хуралдай"—гаас гаргаж байгаа шийдвэр нь ихэвчлэн улс орны хувь заяатай шууд холбоо бүхий, дийлэнх нь эрх зүйн хэм хэмжээ тогтоосон байдаг бөгөөд түүний үйл ажиллагаа нь ч тогтоосон дэг жаягтай, нарийн чанд зохицуулагдсан, оролцох хүмүүс нь ч тодорхой шалгууртай байсан ажгуу.

Ил хаант улсын хувьд Их хуралдайн голлох цөмийг хэдийгээр Хүлэгүгийн угсааныхан бүрдүүлж байсан боловч зарим тохиолдолд орон нутгийн эрх баригчид, эрдэмтэн мэргэд, лам хувраг, хуульчид, иргэдийн төлөөлөгчид орлцож байсан тухай мэдээ байна. Тухайлбал Хүлэгү хаан Багдадын Халифатыг эзлэх байлдааны төгсгөлийн үеэр лалын имам,

[279] Дашням И. Монгол улсын төр эрх зүйн түүх. II УБ.,2011.т.445

[280] Дашням И. Монгол улсын төр эрх зүйн түүх. II УБ.,2011.т.450

[281] Нацагдорж Ш. Чингис хааны цадиг. УБ.,1991.т.131; Далай Ч., Монголын түүх их Монгол улс (1206-1260). боть II. УБ.,1994.т.84; Мишель Хоанг. Эзэн Чингис хаан. УБ., 2000.т.154

[282] Рашид ад Дин. Судрын чуулган. Орч. Сүрэнхорлоо.II дэвтэр УБ.,2002.т.13-14; Рашид ад Дин. Судрын чуулган. Орч. Сүрэнхорлоо. III дэвтэр УБ.,2002.т.63-65; Дашням И. Монгол улсын төр эрх зүйн түүх. II УБ.,2011.т.395

[283] Болдбаатар Ж, Лүндээжанцан Д. Монгол улсын төр эрхзүйн түүхэн уламжлал. УБ.,1997.т. 52-53

хуульчид, эрдэмтэд Багдад хотод бий болсон нөхцөл байдлын талаар[284], Газан хаан 1300 онд Марагад одон орныг судлах төвийн байгууламжийн асуудлаар эрдэмтэн, барилгачидтай уулзан хуралдаж[285] асуудлыг шийдвэрлэж байжээ.

Их монгол улсын үеэс шүүх үйл ажиллагаа төрийн нэрийн өмнөөс хааны шууд удирлагад доор тусгайлан бэтгэгдсэн заргачаар дамжуулан явагддаг байв. Энэ журам ч нүүдэлчин болон суурьшмал иргэд хосолсон Ил хаант улсад мөн адил хэрэгжиж хаан шүүхийн дээд эрхийг эдэлж, шүүхийн бодлогыг тодорхойлж, хяналт тавьж, яллах, ялаас хэлтрүүлэх, өршөөл үзүүлэх эрх эдэлж, эцсийн шийдвэрийг гаргаж, орон нутгийн шүүхэд заргач нарыг болон холбогдох албан тушаалтныг томилж байв. Хааны дараа ерөнхий шүүгч буюу их заргач дэргэд нь ажиллаж, түүний удирдлагад байцаагч түшмэл, гэрчлэгч түшмэл, орчуулагч туслагч түшмэл, бичээч түшмэл, бичээч нар ажиллаж байв. Ил хаант улсын шүүхийн тогтолцоо нь дээд ба орон нутгийн шүүх гэсэн хоёр хэсгээс бүрдэж байв. Дээд шүүх шууд хааны удирдлаган доор байсан бол муж, хот, мянгатын шүүх орон нутгийн шүүхийн тогтолцоог бүрдүүлж байжээ.

Ил хаант улсын эрх зүйн шинж чанарыг бүхэлд нь доктор И.Дашням "Хүлэгүгийн хаант улсын эрх зүйн шинж чанар чиг үүрэг зорилго нь хааны хэмжээгүй эрх, халдашгүй байдал, орд өргөө, хаан хатад, хаан удмыхны аюулгүй байдал, улсын хил хязгаар, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах, улс орны аж ахуй соёлыг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрэлдүүлэх төдийгүй тэдгээрийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, зөрчил, дутагдал доголдол, хор хохирлыг арилгах, хүн зон олны нэр төр, амь нас, бие бялдар, эрх эрх чөлөө, орон сууц, өмч хөрөнгө, мал амьтан эд агуурс, бүтээл туурвилыг хамгаалах, энх амгалан амар тайван амьдарч аж төрөх нөхцлийг бүрэлдүүлэхэд оршиж улс оршин тогтнохын улс төр, хууль зүйн үндэс нь эрх зүй, түүний хэм хэмжээ, хийсвэр ба материаллаг агуулга, ил хаад, төр засгийн улс төрийн бодлогын илэрхийлэл байсан авай"[286] гэж дүгнэжээ.

Энэ бүхнээс үзэхэд Ил хаант улсын эрх зүйн тогтолцоог цөөн хэдэн жишээ дээрээс харвал "Их засаг"- аас уламжилсан хэм хэмжээ байхаас гадна исламын ертөнцийн өөрийнх онцлог хэв шинж бүхий эрх зүйн тогтолцоотой байна. Ил хант улс нь улс төрийн бодлогын хувьд Их Монгол улс, Монголын эзэнт гүрний төрийн бодлогыг хэрэгжүүлж, газар нутгийн хувьд Иран, Кавказын чанад, Дундад Ази, Афганистан, Месопотами, Бага Азийн зүүн хэсгийг өөртөө нэгтгэжээ. Эзэнт гүрний бүрэлдэхүүн улсуудаас хамгийн сүүлд үүсэн байгуулагдаж нийт 88 жил оршин тогтносон Ил хаант улсын төрийн бодлого нь тухайн бүс нутгийн нийгэм, эдийн засаг, соёл, эрх зүйн орчинг хөгжүүлэхэд ихээхэн нааштай үүрэг гүйцэтгэжээ.

[284] Мустафа Таха Бадр. Лалд учирсан их гамшиг буюу Багдад Монголчуудын гарт мөхсөн нь. Орч. К.Кекен Кайр, 2006.т.36; Дашням И. Монгол улсын төр эрх зүйн түүх. II УБ.,2011.т.395

[285] Рашид ад Дин. Судрын чуулган. Орч. Сүрэнхорлоо. III дэвтэр. УБ.,2002 .т.205; Дашням И. Монгол улсын төр эрх зүйн түүх. II УБ.,2011.т.395

[286] Дашням И. Монгол улсын төр эрх зүйн түүх. II УБ.,2011.т.451